



## ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 06 сарын 04 өдөр

Дугаар А/324

Хэрлэн сум

### Хүндэтгэл үзүүлэхэд хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2 дугаар зүйлийн 2.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Буриад ард түмний түүх соёл, өв уламжлалыг харуулсан Хайрын домог уран сайхны киног аймаг орон нутгийн иргэдэд үнэ төлбөргүй үзүүлж, нутаг орны онцлогыг телевизийн дэлгэцэнд мөнхлөн үлдээсэн явдалд талархал илэрхийлж Төрийн соёрхолт, Урлагийн гавьяат зүтгэлтэн Л.Балхжавд хүндэтгэл үзүүлэхэд шаардлагатай 1,670,000 (нэг сая зургаан зуун далан мянган) төгрөгийн хөрөнгийг зарцуулсугай.

2.Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн шагнал урамшуулал, нэг удаагийн буцалтгүй тусламж, дэмжлэгийн зардлаас олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Гантулга)-д, гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ